ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

ЭБО ИНВЕСТ ББСБ ХХК

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

УЛААНБААТАР ХОТ
2021 он

“ЭБО ИНВЕСТ ББСБ” ХХК-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

DUM AUDIT
БҮРТГЭЛ, ХЯНАЛТ, ЗӨВЛӨГӨӨ

ДУНДМАНХАЙДАЙ
АУДИТ ХХК

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бакула Ринбүүчийн гудамж, Оршил-2 төв, 5 давхар,
Утас: 9908 5151, 9199 1462, Факс: (976-11) 32 52 62,
И-мэйл: byambaahunnu@yahoo.com, Вэб: www.dumaudit.mn

2021.02.08 № 3

танай _____-ны №_____-т

ДУМ-СТА-2021-01

"ЭБО ИНВЕСТ ББСБ" ХХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БОЛОН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ХОНГОРЗУЛ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хүлээн авагчийн хаяг: УБ хот БГД 17-р хороо,
4-р хороолол, Жалханзхутагт Дамдинбазарын гудамж
ЭБО төв 301 тоот

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Бид 2020 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "ЭБО инвест ББСБ" –ХХК-ний санхүүгийн тайланд аудитын ажил хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны "Заавар шинэчлэн батлах тухай" 249 дугаар, 2017 оны "Маягт заавар батлах тухай" 361 дугаар тушаалууд, Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомж эрх зүйн орчны "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 6.1.2 дахь заалт, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн хуулийн дагуу бэлтгэгдсэн болно.

Бидний дүгнэлтээр, "Эбо инвест ББСБ" – ХХК-ний 2020 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Яамны болон холбогдох хууль, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу ББСБ-аас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсанí аудитын баримт нотолгоо

нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад Мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу жилийн тайлан бэлтгэдэггүй. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь Монгол Улсын Сангийн сайдын 2014 оны "Заавар шинэчлэн батлах тухай" 249 дугаар, 2017 оны "Маягт заавар батлах тухай" 361 дугаар тушаалууд, Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомж эрх зүйн орчны "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.10, 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтууд, Банк бус санхүүгийн байгууллагад мөрдөх "Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар"-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага ББСБ-ын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь ББСБ-ын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах iь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитын ажил нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн баримт хамруулаагүй бөгөөд санхүүгийн тайлангуудын уялдааг шинжлэх, асууж ярилцах, журналуудыг тулган шалгах зэрэг горимуудаар хязгаарлагдсан болно.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталсан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ББСБ-ын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн ББСБ-ын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах ^{9}дөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал ББСБ-ын тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц дутагдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйл, 95.1 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий этгээдэд танилцуулахад зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Аудитын компанийн нэр: Дүнжинхайдай аудит ХХК
Аудиторын нэр: Ж.Бямбажав
Огноо:2021.02.08
Аудиторын Хаяг: УБ хот ЧД-2-р хороо Бакула Ринбүүчийн гудамж
Оршил-2 тов 5 давхарт

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүй болохыг анхаарна уу.

ЭБО ИНВЕСТ ББСБ ХХК

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант үе: 2020.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	**ХӨРӨНГӨ**	**1,763,329,606.89**	**2,274,334,170.32**
I.1	**А.Эргэлтийн хөрөнгө**	**1,755,754,884.89**	**2,266,535,005.32**
1	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	**24,327,967.14**	**142,305,202.57**
1.1	Бэлэн мөнгө	6,927,659.26	85,696,971.26
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	17,400,307.88	56,608,231.31
3	**ЗЭЭЛ/ЦЭВРЭЭР/**	**1,560,145,857.75**	**1,683,004,316.75**
3.1	Нийт зээл	1,597,899,718.00	1,735,814,302.00
3.1.1	Хэвийн зээл	1,457,633,777.00	1,580,123,861.00
3.1.2	Хугацаа хэтэрсэн зээл	58,500,000.00	77,500,000.00
3.1.3	Чанаргүй зээл	81,765,941.00	78,190,441.00
3.1.3.1	Хэвийн бус зээл	39,441,441.00	35,865,941.00
3.1.3.2	Эргэлзээтэй зээл	34,712,000.00	4,712,000.00
3.1.3.3	Муу зээл	7,612,500.00	37,612,500.00
3.1.4	(Эрсдлийн зээлийн сан)	-37,753,860.25	-52,809,985.25
7	**БУСАД АВЛАГА**	**170,827,860.00**	**440,796,697.00**
7.1	**Бусад авлага**	**1,197,260.00**	**1,886,884.00**
7.3	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	169,630,600.00	438,909,813.00
7.3.1	Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	169,630,600.00	438,909,813.00
8	БУСАД ХӨРӨНГӨ	453,200.00	428,789.00
8.4	Материал, үнэ бүхий зүйлс	453,200.00	428,789.00
9	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	1,755,754,884.89	2,266,535,005.32
10.3	Эд хогшил	10,117,340.00	10,117,340.00
10.4	Хуримтлагдсан элэгдэл (эд хогшил)	3,024,201.00	4,035,941.00
10.5	Техник хэрэгсэл	2,402,500.00	3,267,000.00
10.6	Хуримтлагдсан элэгдэл (техник хэрэгсэл)	2,264,433.00	1,598,306.00
11.1	Биет бус хөрөнгө	343,516.00	49,072.00
12	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,574,722.00	7,799,165.00
13	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,763,329,606.89	2,274,334,170.32
20.1	Энгийн хувьцаа	1,400,000,000.00	1,900,000,000.00
20	ХУВЬЦААТ КАПИТАЛЫН ДҮН	1,400,000,000.00	1,900,000,000.00
21.5	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	668,037.27	2,114,592.22
21.5.1	Тайлант үеийн ашиг /алдагдал/	351,446,554.95	372,219,578.10
22	ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	1,752,114,592.22	2,274,334,170.32
23	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,763,329,606.89	2,274,334,170.32

ЭБО ИНВЕСТ ББСБ ХХК

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант үе: 2020.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	**ХҮҮГИЙН ОРЛОГО**	**459,317,475.34**	**438,430,085.02**
1.1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	454,510,529.00	429,623,957.00
1.2	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	4,144,803.00	7,806,919.50
1.8	Харилцах дансны хүүгийн орлого	662,143.34	999,208.52
3	**ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО (1-2)**	**459,317,475.34**	**438,430,085.02**
4	**ХҮҮГИЙН БУС ОРЛОГО (4.1+4.2+4.3)**	**4,342,617.82**	**300,384.98**
4.2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн	37,508.50	30,420.98
4.2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн	37,508.50	30,420.98
4.3	Санхүүгийн үйлчилгээний	4,305,109.32	269,964.00
4.3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн	4,305,109.32	269,964.00
5	**ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ (5.1+5.2+5.3)**	**46,604,408.20**	**51,454,766.90**
5.1	Арилжааны болон ханшийн тэгшитгэлийн	19,105.08	6,855.56
5.1.3	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн	19,105.08	6,855.56
5.2	Боловсон хүчний холбогдолтой зардал	24,611,120.00	29,098,500.00
5.2.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	21,400,000.00	27,600,000.00
5.2.6	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн	2,536,120.00	1,498,500.00
5.2.8	Сургалтын зардал	675,000.00	0.00
5.3	Бусад зардал (5.3.1+..5.3.26)	21,974,183.12	22,349,411.34
5.3.2	Зээл болон түүнтэй холбоотой авлагыг	1,110,935.00	0.00
5.3.6	Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	1,000,000.00	2,000,000.00
5.3.8	Түрээс	13,500,000.00	13,600,000.00
5.3.10	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	1,836,414.00	1,490,057.00
5.3.12	Харилцаа холбоо, интернет	527,450.00	1,367,961.00
5.3.13	Шатахуун болон тээврийн зардал	120,000.00	60,000.00
5.3.15	Зохицуулалтын хураамжийн зардал	1,440,000.00	2,520,000.00
5.3.17	Захиалгат хэвлэлийн зардал	59,400.00	0.00
5.3.20	Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	936,800.00	260,000.00
5.3.21	Бичиг хэргийн зардал	345,562.50	223,710.00
5.3.22	Ариун цэврийн зардал	12,297.00	81,511.00
5.3.24	Харилцагчдын сургалт судалгааны зардал	600,000.00	0.00
5.3.25	Бусад	485,324.62	746,172.34
6	**ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС**	**-42,261,790.38**	**-51,154,381.92**
7	**БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН САН**	**417,055,684.96**	**387,275,703.10**
8	**БОЛЗОГШҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ**	**29,211,448.30**	**15,056,125.00**
8.2	Зээлийн эрсдэлийн зардал	29,211,448.30	15,056,125.00
9	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/**	**387,844,236.66**	**372,219,578.10**
10	**ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ**	**2,650,000.00**	**0.00**
10.1	Алданги	2,650,000.00	0.00
11	**ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ**	**109.32**	**0.00**
11.5	Бусад	109.32	0.00
12	**ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/**	**390,494,127.34**	**372,219,578.10**
15	**ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/**	**390,494,127.34**	**372,219,578.10**
16	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	39,047,572.39	0.00
17	**ЦЭВЭР АШИГ/ АЛДАГДАЛ (15-16)**	**351,446,554.95**	**372,219,578.10**

ЭБО ИНВЕСТ ББСБ ХХК

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2020.12.31

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	Нийт дүн
1	**2018 оны 12 сарын 31- ээрх үлдэгдэл**	**1,000,000,000.00**	**0.00**	**0.00**	**0.00**	**261,668,037.27**	**1,261,668,037.27**
7	Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	0.00	351,446,554.95	351,446,554.95
8	Хуваариласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	-261,000,000.00	-261,000,000.00
9	Хувьцаат капиталын өсөлт	400,000,000.00	0.00	0.00	0.00	0.00	400,000,000.00
10	**2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**1,400,000,000.00**	**0.00**	**0.00**	**0.00**	**352,114,592.22**	**1,752,114,592.22**
17	Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	0.00	372,219,578.10	372,219,578.10
18	Хуваариласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	-350,000,000.00	-350,000,000.00
19	Хувьцаат капиталын өсөлт	500,000,000.00	0.00	0.00	0.00	0.00	500,000,000.00
20	**2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**1,900,000,000.00**	**0.00**	**0.00**	**0.00**	**374,334,170.32**	**2,274,334,170.32**

ЭБО ИНВЕСТ ББСБ ХХК

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант үе: 2020.12.31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Хэсгийн дүн	Бүлгийн дүн
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДҮН**	**117,977,235.43**	**117,977,235.43**
1.1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого**	**931,083,854.00**	**931,083,854.00**
1.1.1	Зээлийн хүүгийн орлого	7,806,919.50	7,806,919.50
1.1.4	Харилцах дансны хүүгийн орлого	999,208.52	999,208.52
1.1.9	Гадаад валютын ханшийн зөрүү	30,420.98	30,420.98
1.1.12	Мөнгөн гуйвуулгын орлого	380,300,000.00	380,300,000.00
1.1.16	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	269,945.00	269,945.00
1.1.18	Бусад үйлчилгээний орлого	541,677,360.00	541,677,360.00
1.2	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**813,106,618.57**	**813,106,618.57**
1.2.5	Үндсэн ба нэмэгдэл цалин	25,115,850.00	25,115,850.00
1.2.7	Нийгмийн даатгал, ЭМД-ийн зардал	3,458,000.00	3,458,000.00
1.2.9	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	13,600,000.00	13,600,000.00
1.2.10	Шатахуун, холбоо, интернет, сэлбэр хэрэгсэлд төлсөн мөнгө	1,427,961.00	1,427,961.00
1.2.11	Бичиг хэрэг, ариун цэврийн зардал	129,900.00	129,900.00
1.2.12	Татвар, даатгалын төлсөн мөнгө	46,739,646.67	46,739,646.67
1.2.13	Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	260,000.00	260,000.00
1.2.19	Аудитын төлбөр,мэргэжлийн зөвөлгөө үйлчилгээний мөнгө	2,000,000.00	2,000,000.00
1.2.20	Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	2,520,000.00	2,520,000.00
1.2.21	Ногдол ашгаар олгосон мөнгө	195,300,000.00	195,300,000.00
1.2.22	Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	1,964,410.00	1,964,410.00
1.2.23	Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	520,590,850.90	520,590,850.90
3	**БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**117,977,235.43**	**117,977,235.43**
4.1	**МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ**	**24,327,967.14**	**24,327,967.14**
4.2	**МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ**	**142,305,202.57**	**142,305,202.57**

